

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Мижидийн Лхамсүрэн	Дугаар	L026
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Баянзүрх дүүрэг
Төрсөн газар	Төв аймгийн Лүн сум	Төрсөн он	1914
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Лүн сумын Цагаан толгойн жас, Хүрээний Вангай болон Зоогой аймгийн дуган	Сүм хийдийн дугаар	UBNR 942 ,ТӨЛҮ 017
Одоогийн сүм хийд	Дашчойлин хийд	Сүм хийдийн дугаар	UB 02
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Төв аймгийн Лүн сумын Цагаан толгойн жас, Хүрээний Вангай болон Зоогой аймгийн дуган

Манай эжий хүүгээ ном үзүүлнэ гээд 13 настай байхад хотод дагуулж ирсэн. Санжаа ах хар болго гэж хэлж байсан. Тэгэхэд энэ хурал ном хаагдах болоогүй байсан. Тэгсэн эхнэр нь Санжаа ахыг загнаад хүн хүүгээ ном үзүүлнэ гэж байхад гэж байсан юм. Миний төрсөн ах надаас 6 ах. Тэр ах Ганданд байсан. Ижий маргааш нь ахад намайг хүргэж өгч дүүгээ номтой хүн болго гэсэн. За нэг хүнд шавь оруулчихна даа гэсэн. Тэгээд би Вангай аймагт 10 гаран настай аймагласан юм. Гандан чинь их хатуу. Хоол унд бага өгнө. Бага унтуулна. Эрт босгоно. Гэр хүйтэн. Муу аав, эжий хоёрыгоо санаад харих юмсан гэж бодоод. Тэгээд цагаан сарын 15 хүргээд нутгийн аянчин дагаад харьж байсан юм. Хойтон жил нь дахиад суу гээд. Манай эжий л суулгах гэдэг байсан юм. Аав бол тэг ч гэхгүй байг ч

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гэхгүй л байдаг байсан. Тэгээд бас очлоо. Манай нутгийн нэг хүн чи хаана аймагласан гэлээ. Вангай аймагт гэсэн чинь чи хошууны аймагт аймаглаж яаж байгаа юм шавь хүн байж гэж байсан. Урд чинь хошууны аймаг шавийн аймаг гэж байсан юм. Манай нутаг бол Богдын шавь газар байсан юм. Тэгээд би Зоогой аймагт аймаглалаа.

Хүрээнд

1. Шүтээний
- 2.Дондовлин
- 3.Жиддаран
- 4.Даштойсомлин
- 5.Дүйнхорын
- 6.Цэцэн тойны
- 7.Андуугийн
- 8.Дашдандарлин
- 9.Маяагийн
- 10.Жасын гээд 10 аймаг,

- 1.Номч
- 2.Сангай
- 3.Зоогойн
- 4.Дугарын
- 5.Чойнхорлин
- 6.Мэргэн хамбын
- 7.Бизъяагийн
- 8.Хүүхэн ноёны
- 9.Дархан эмчийн
- 10.Эрхэм тойны гээд 10 аймаг,

- 1.Эх дагинын
- 2.Вангайн
- 3.Хувилгааны
- 4.Баргын
- 5.Намдоллин
- 6.Бандидын
7. Сүнгийн
- 8.Лам нарын
- 9.Мэргэн номун ханы

10.Өрлүүдийн гээд 10 нийт 30 аймаг байсан юм. Хүрээнд 10 дацан байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Би 16,17 хүртлээ хурсан юм. Тэгээд Дашчоймбэлд 2, 3 жил хурсан. Хадаг гээд шидүв хүрээд л хурал хаагдсан даа. Манай зиндаа 200 гаруй ламтай байсан. Зиндааны анги нь Сундуйжав, Доржсэмбэ гэж байсан.

Цагаан толгойн хуралд 6 настай очиж сахил авч лам болж байсан. Жаахан хүүхэд өглөө, орой нь номоо заалгаад, өдөр нь хонио хариулаад явдаг байсан. Ер хөдөөний хүүхдүүд ажлаа хийгээд номоо үзээд бүгд л тиймэрхүү байдаг байсан.

Цагаан толгой гэж тахидаг жаахан толгой бий. Тэр ухаагийн үзүүр дээр дуганаа барьсан юм. Цагаан толгойн хуралд 40,50-иад лам байсан. Ганцхан дугантай. Орон нутгийн улсуудын санал хүсэлтээр байгуулсан юм билээ. Миний багш Намсрай гэж өвгөн лам байсан. Тэргүүн нь байсан. Их настай хүн байсан. Татагдаад явсан. Гэсгүй нь Жаалдагва гэж хүн байсан.

Дээр үед хэдэн азар явж байжээ. Нэг азарын авгай нь төрөх болчихсон байж гэнэ. Азарууд нь нөгөө төрөх дөхсөн авгайг нөхөртэй нь орхиод явсан. Тэр азар эмэгтэй төрөөд Сангай аймгийн Ренчиндорж нэртэй нэг мундаг лам гарчээ. Тэр хүн Богдын урдаа барьдаг цорж болсон юм байх. Манай Цагаан толгойн тэнд шарил нь байсан. Ер нь тэр ламын үед л байгуулсан юм шиг байгаа юм. Тэр хүний л мэдлийн газар байсан юм шиг байгаа юм. Хурал 1910-д онд байгуулагдсан болов уу.

Гол шүтээн нь Лхам, Жамсран байсан.

Шинийн 8-нд хурна. Дүйчэнгүүдээр хурна. Мэжирийн Дончид хурна. Цагаан сарын үед цагийн хурал гэдэг хурал байдаг. Хуучин ном, Цэдор хурна. Шинийн нэгнээс авахуулаад 15 хоног Цагаан сарын ерөөл хурна. Битүүний шөнө шөнөжин нойргүй хуучин ном хурна. Тэрнээсээ өмнө Хангал хурдаг байсан. Сор залдаггүй байсан. Бурхан багшийн дүйчэн өдрөөр Бурхан багшийн чог хурна. Цам, Майдар, Ганжуур эргэдэггүй байсан. Аймагтай, дацантайг хүрээ гэдэг.

Манай жас модон дугантай байсан. Өвөлдөө гэр барьж хурна. Хурал номыг ардууд нь хурлаа санал гаргаад л хуруулчихна.

Лүйжинч, зодоч лам нар цөөн байсан. Гэхдээ манай хуралд хамаарахгүй.

Манай хурлын ойролцоо Маналын жас, Улаан толгойн жас, Цэгээний жас, Энхийн жас, Өвөр Долоодын жас, Ар Долоодын жас гэж байсан.

Өдөр тутам малаа хариулна. Айлын гэрт очиж ном уншиж өгнө. Өвчин энэ тэр гарвал айлд гүрэм хийнэ.

Хятадын пүүс, худалдаа байсан. Гурил будаа, даавуу даалимба байсан. Урд малаараа л амьдарч байлаа. Манай жасад сууж байсан хүн одоо байхгүй. Настай лам нарыг нь барьж аваад явчихсан. Тэндээс 3, 4 хүн баригдсан.

Цэрэгт явж ирээд, мал маллаж байгаад гар үйлдвэрт ажилласан. Эргээд лам болж 1992, 1993 оны үед Дашчойлинд хурж эхэлсэн.